

I-III/2021

Тархаасан: 2021 оны 4 дүгээр сарын 15




Орон сууцны үнэ өмнөх улирлаас 0.2 хувиар буурсан байна.


Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэгт орон сууцны үнэ 2021 оны 1 дүгээр улиралд 2010 оны эцсээс 78.4 хувиар өсөж, өмнөх оны мөн үеэс 0.4, өмнөх улирлаас 0.2 хувиар тус тус буурсан байна.

Орон сууцны үнэ 2021 оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс Сонгинохайрхан дүүрэгт 3.6, Чингэлтэй дүүрэгт 0.7, Баянзүрх дүүрэгт 0.6 хувиар тус тус буурсан байна. Харин Хан-Уул дүүрэгт 1.3, Баянгол дүүрэгт 0.8, Сүхбаатар дүүрэгт 0.5 хувиар тус бүр өссөн байна.

Зураг 1: Орон сууцны үнийн индекс, хувиар, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар



Зураг 2: Орон сууцны үнийн индекс, хувиар, өмнөх улиралтай харьцуулснаар



Орон сууцны үнэ 2021 оны 1 дүгээр улиралд өмнөх улирлаас Сонгинохайрхан дүүрэгт 1.7, Баянзүрх дүүрэгт 0.5 хувиар тус тус буурсан байна. Харин Сүхбаатар дүүрэгт 0.6, Баянгол, Чингэлтэй дүүрэгт 0.2, Хан-Уул дүүрэгт 0.1 хувиар өссөн байна.

Ойлголт, тодорхойлолт:

Нийтийн орон сууц гэж зориулалтын зураг, төслөөр баригдсан, бүтэц хийцийн хувьд бүхэлдээ буюу ихэнх хэсэг нь дөрөв, түүнээс дээш сууцны зориулалттайгаар төхөөрөмжлөгдсөн (байшингийн хэмжээ, давхар, хэдэн айл суух зориулалттайгаас үл хамааран), дэд бүтцийн хангамжтай байшинг ойлгоно.

Жин нь нийт сууцны талбайн өртөгт тухайн бүлгийн орон сууцны талбайн өртгийн эзлэх хувь хэмжээ юм.

Тооцох аргачлал:

Орон сууцны үнийн индексийг тооцоход Ласпейресийн хувиргасан индексийн томъёогоор тооцно. Үүнд:

$$I_{ct}^L = \sum \left(\frac{P_{it}}{P_{it-1}} \right) \left(\frac{P_{it-1}}{P_{it-2}} \right) \dots \left(\frac{P_{i2}}{P_{i1}} \right) \left(\frac{P_{i1}}{P_{i0}} \right) \frac{P_{i0} Q_{i0}}{\sum P_{i0} Q_{i0}}$$

энд,

I_{ct}^L – t үеийн c-бүлгийн(агрегатын) Ласпейресийн индекс,

P_{it} – i орон сууцны t тайлант үеийн үнэ,

P_{i0} – i орон сууцны 0 суурь үеийн үнэ,

Q_{i0} – 0 суурь үеийн i төрлийн сууцны өртгийн нийт орон сууцны өртөгт эзлэх хувь

Эх үүсвэр: ҮСХ, Орон сууцны үнийн мэдээ

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархах хуваарь: 2021 оны 7 дугаар сарын 12

Эдийн засгийн статистикийн газар
дарга Э.Эрдэнэсан
Утас : (976-51)-266414

Эдийн засгийн статистикийн газар
шинжээч Б.Оргил
Утас : (976-51)-261561

